A world map with various countries labeled. The map is color-coded: North America (Canada, USA) is light green; Russia is yellow; Europe and parts of Asia are purple; Africa and South America are grey; and other regions like Australia and parts of Asia are orange. Labels include: Greenland, Canada, United States of America, Mexico, Peru, Brazil, Bolivia, Chile, Norway, Spain, Italy, Algeria, Nigeria, Angola, Ethiopia, Egypt, Sudan, Turkey, Kazakhstan, Mongolia, Pakistan, India, and Russian Federation.

Эрдсийн бүтээгдэхүүний үнэ тогтоох аргачлал, олон улсын онол, практик

**Монголын Экспортлогчдын Холбоо
Ерөнхийлөгч Д.Галсандорж**

2014.09.24

АГУУЛГА



- 1. Эрдсийн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ бүрдэх зарчим**
 - Биржийн бараа
 - Биржийн бус бараа (төмөр, жонш, нүүрс)
- 2. Эрдсийн бүтээгдэхүүн худалдаалах олон улсын нөхцөл**
 - “Инкотерм ”Олон улсын худалдаа хийх, нийлүүлэх ерөнхий нөхцөл
 - Худалдагч, худалдан авагчдын эрх, үүрэг
- 3. МУ-ын эрдсийн бүтээгдэхүүний үнэ тогтоох механизмыг боловсронгуй болгох арга зам**
 - Олон улсад мөрдөж байгаа аргачлал
 - Манай улсад мөрдөж буй үнэ тогтоох аргачлал
 - Үнэ тогтоох механизмыг боловсронгуй болгох чиглэл




ЭРДСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ БҮРДЭХ ЗАРЧИМ

Олон улсын зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүн, түүний нэр төрөл, боловсруулалтын түвшин, чанар зэргээс хамаарч худалдагч, худалдан авагчдын хооронд арилжаа хийгдэж байна. Үүнд:

- 1. Биржээр арилжаалах бараа;**
- 2. Биржээр арилжаалдаггүй, биржийн бус бараа;**

Биржээр арилжаалах бараанд:

- **Үнэт металл:** (Алт, мөнгө, цагаан алт)
- **Өнгөт металл:** (Зэс, цайр, хар ба цагаан тугалга, никель, хөнгөн цагаан)



Металлын биржээр арилжаалах бараа

Дэлхийн улс орнуудад **23 металлын бирж** үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт металл:

- **Алт, мөнгө** дийлэнх биржээр;
- **Мөнгө** 13 биржээр;
- **Цагаан алт** 8 биржээр;

Өнгөт металл:

- **Зэс** 12 биржээр;
- **Ган, хөнгөн цагаан** 8 биржээр;
- **Хар, цагаан тугалга** 6 биржээр;

Үргэлжлэл...

- Биржийг Олон улсын, Бүс нутгийн болон тухайн орны үндэсний хэмжээний гэж ангилдаг.
- Металлын биржүүд дээр ихэвчлэн өнгөт ба үнэт металлын өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үнийг тогтоож, бүтээгдэхүүний чанар стандартыг баталж байна.
- ЛМБ, ЛАМБ, ЧХБ, ШФБ бирж дээр үнэ тогтоон зарласан металлуудын үнийг үндэслэн худалдагч, худалдан авагчдын хооронд гэрээний үнийг тохиролцдог.
- Манай экспортын зэс, цайрын баяжмалын үнийг худалдан авагчтай тохиролцохдоо ЛМБ-ийн сарын дундаж үнийг ихэвчлэн хэрэглэж байна.



Биржийн бус бараа

1. Төмөр, жонш болон нүүрсийг арилжаалах олон улсын ба бүс нутгийн бирж одоогоор дэлхийн орнуудад байхгүй байна.
2. Биржээр арилжаалахгүй барааг “биржийн бус бараа” гэж нэрлэж байна.
3. Биржийн бус барааны хувьд жишиг үнийг тогтоохдоо олон улсын хэмжээний томоохон худалдагч, үйлдвэрлэгч орон, худалдан авагч, хэрэглэгчдийн хооронд байгуулсан гэрээний “benchmark price”(жишиг үнэ)-ийг тухайн орны онцлогт тохируулан тооцон хэрэглэх практик мөрдөж байна.

Инкотерм, нийлүүлэлтийн цэг

Төмрийн хүдэр:

- Томоохон үйлдвэрлэгч орон – Австрали, Бразил, Өмнөд Африкийн **FOB** үнэ эсвэл Хятад **CIP**, **CFR** үнийг жишиг болгодог.

Мэдээллийн эх сурвалж: www.umetal.com, www.platts.com,
www.asianmetals.com

Жонш:

- Томоохон үйлдвэрлэгч орон -Мексик, Хятадын **FOB** үнэ эсвэл ОХУ, АНУ-ын **CIP** үнийг жишиг болгодог.

Мэдээллийн эх сурвалж: www.indmin.com, www.platts.com,

Нүүрс:

- Нүүрсний хувьд томоохон үйлдвэрлэгч орон –Индонез, Австралийн **FOB** үнэ эсвэл Хятад, Японы **CIP** үнийг жишиг болгодог.

Мэдээллийн эх сурвалж: www.en.sxcoal.com, www.platts.com,
www.coalworld.com

Инкотермс FOB, CIP, DAP, EXW НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЦЭГ, ҮНЭ

1. FOB (Free on board) үнэ:

- Худалдагч орны далайн боомтын үнэ
- Энэ үнэд тухайн барааны үнэ, уурхайгаас далайн эрэг хүртэлх тээврийн зардал, далайн боомт дээрх ачиж буулгах зардал ордог.

2. CIP (Cost, Insurance, Freight) үнэ:

- Худалдан авагч орны хилийн үнэ (далайн боомт хүргэх үнэ)
- Энэ үнэд барааны үнэ, худалдан авагч орны далайн эрэг хүртэлх тээврийн зардал, тээврийн ачиж буулгах зардал багтана

3. EXW (Exwork) үнэ:

- Агуулахын буюу уурхайн амны үнэ
- Энэ үнэд барааны үнэ, уурхайн амны ачилтын зардал багтана.

4. DAP (DAPoint) үнэ:

- Худалдагч орны хилийн үнэ
- Энэ үнэд барааны үнэ, хил хүртэлх тээврийн зардал, ачиж буулгах зардал зэрэг багтана.



Индонез, Казакстаны жишиг үнэ тооцох практик

- Жишиг үнийг тооцдог бөгөөд тухайн эрдсийн өөрийн орны FOB ба DAP үнийг боомтуудаар тооцоолон зарлаж, зэс зэрэг өнгөт металлын хайлуулах цэвэршүүлэх зардлыг хасч тооцож байна.
- Нүүрсийг боловсруулсан тохиолдолд боловсруулалтын зардлыг хасч тооцдог.
- Казакстаны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээний үнээр тооцож байна.

МУ-д жишиг үнэ тогтоож буй өнөөгийн практик

1. Нүүрс

- Нүүрс DAP (Шивээхүрэн, Гашуунсухайт) буюу EXW нөхцлөөр нийлүүлж байгаа боловч www.en.sxcoal.com зарлаж байгаа үнийг ашиглаж байна.

2. Жоншны баяжмал

- Жоншны баяжмалыг DAP ОХУ, Хятадын хил нөхцлөөр нийлүүлж байна. Гэвч Хятадын ФОБ үнэ, www.indmin.com үнийг шууд авч хэрэглэж байна.

3. Төмрийн баяжмал

- Төмрийн баяжмалыг DAP (Эрээн, Бургастай) нөхцлөөр нийлүүлж байна. Австралийн ФОБ жишиг үнийг шууд авч хэрэглэж байна.

МУ-д жишиг үнэ тогтоож буй ӨНӨӨГИЙН ПРАКТИК

2013 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 131 тоот “Нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолд дараах нэмэлт өөрчлөлтүүд оруулсан.

2. Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монголбанкны болон **зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр**”-ийн 3, 4, 6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3. Төмөр	Австралийн төмрийн хүдэр үйлдвэрлэгчдээс Хятадын ган үйлдвэрлэгчид нийлүүлж байгаа Dampeir/Hedland боомтын FOB үнэ. /www.umetal.com/
4. Хайлуур жонш	Хятадын хайлуур жоншны бүтээгдэхүүний FOB үнэ. /www.indmin.com/
6. Нүүрс	Хятадын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн үнэ. /http://en.sxcoal.com/ ”

МУ-д жишиг үнэ тогтоож буй ӨНӨӨГИЙН ПРАКТИК

Монгол Улсын Сангийн сайд, Уул уурхайн сайдын 2014 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 172/185 тоот хамтарсан тушаалын нэгдүгээр заалтаар:

- Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын **нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийг үнийг нийтэд мэдээллэх** үүрэг бүхий ажлын хэсэг шинэчлэн байгуулсан.

Тус ажлын хэсгийн ажиллах журмын 3.2.-д:

Боловсруулах дэд хороо уул уурхайн бүтээгдэхүүний **зах зээлийн үнийн мэдээллийг холбогдох эх сурвалжаас авч тооцоолон, нэгдсэн санал боловсруулна.**

МУ-д жишиг үнэ тогтоож буй ӨНӨӨГИЙН ПРАКТИК

ЭКСПОРТОД ГАРГАСАН АШИГТ МАЛТМАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭЛЭЛ

2014 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоол, 2010 оны 39 дүгээр тогтоол, 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 89, 220 дугаар тогтоолын дагуу уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг нийтэд мэдээллэж байна.

Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний 2014 оны 8 дугаар сард зарлагдаж буй олон улсын зах зээлийн үнийг 2014 оны 7 дугаар сарын үнийн дунджыг тогтоох зарчмаар тооцсон болно.

/ам.доллар/

Жонш	Хайлуур жоншны баяжмал ФФ-97	315.00	www.indmin.com
	Хайлуур жоншны баяжмал ФФ-95	308.51	
	Хайлуур жоншны баяжмал ФК-92	259.76	
	Хайлуур жоншны хүдэр ФК-85	240.00	
	Хайлуур жоншны хүдэр ФК-80	210.00	
	Хайлуур жоншны хүдэр ФК-75	196.88	
Төмрийн хүдэр	Бүхэллэг хүдэр /58 хувийн агуулга/	80.57	www.umetal.com
	Нунтаг хүдэр /58 хувийн агуулга/	72.91	

МУ-д жишиг үнэ тогтоож буй ӨНӨӨГИЙН ПРАКТИК

Country	Product	% Grade	CFR (\$/DMT)	Change	FOB (\$/DMT)	Change	POL	Remark
Australia	PB Fines	61.5	95	→	87	→	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	Newman Fines	63	96	→		→	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	MAC Fines	61.5	94	→		→	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	Yandi Fines	58	82	→	74	→	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	Robe River Fines	56	79	→	71	→	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	PB Lumps	62	103	→	95	→	Dampier/Hedland	Moisture: 3%
Australia	Newman Lumps	63	104	→	96	→	Dampier/Hedland	Moisture: 3%
Australia	MAC Lumps	62	102	→	94	→	Dampier/Hedland	Moisture: 3%
Australia	Yandi Lumps	58	90	→	82	→	Dampier/Hedland	Moisture: 3%
Australia	Newman Fines	62	-	-	-	-	Dampier/Hedland	Moisture: 8%
Australia	MAC Fines	62	-	-	-	-	Dampier/Hedland	Moisture: 8%

**/ - Сарын дундаж үнэ (2014.07.01-2014.07.31): Бүхэллэг хүдэр – 80.57 USD/t
Нунтаг хүдэр – 72.9 USD/t

Төмрийн хүдрийн жишиг үнийг тооцохдоо www.umetal.com -д зарласан Австралийн төмрийн хүдрийн FOB үнийн сарын дундажийг шууд авчхэрэглэж, АМНАТ тооцож байна.

МУ-д жишиг үнэ тогтоож буй ӨНӨӨГИЙН ПРАКТИК




Global non-metallic miner... Монголбанк Mongolian Coal Price at China...
www.indmin.com/Prices/PriceDetail.aspx?ID=FL-P15
Fluorspar, Acid Grade, Filtercake, Wet, FOB, China, \$/tonne

Date	Low Range	High Range
31 Jul 2014	300.00	330.00
24 Jul 2014	300.00	330.00
17 Jul 2014	300.00	330.00
10 Jul 2014	300.00	330.00
03 Jul 2014	300.00	330.00
26 Jun 2014	310.00	340.00

>>Back to product list


*/ - ФФ-97 хайлуур жоншэы сарын дундаж үнэ: 315 USD/t

Тухайлбал “ФФ-97 хайлуур жоншны баяжмал”-ын жишиг үнийг тооцохдоо www.indmin.com –д байгаа Хятадын FOB үнийн дөрвөн 7 хоногийн үнийн дундажийг шууд авч хэрэглэж байна.




Үнэ тогтоох аргачлалыг боловсронгуй болгох арга зам

1. Эрдсийн бүтээгдэхүүний үнийн мэдээллийг хэвлэн гаргадаг олон улсын мэдээллийн эх сурвалжуудын жагсаалтыг гаргаж, тэдгээрээс манай орны нөхцөлд ашиглаж болох үнийн эх сурвалжийг тодорхойлох;
2. “Жишиг үнэ” тооцоолох аргачлалыг шинэчлэн боловсруулах.



Үнэ тогтоох аргачлалыг боловсронгуй болгох арга зам

3. Экспортод гаргах эрдсийн бүтээгдэхүүний үнэлгээ (АМНАТ)-г уурхайн байршил, бүтээгдэхүүний чанарыг харгалзан “хил нөхцөл” ба “уурхайн ам”-аар тооцдог болох.
 - Тухайлбал нүүрсийн үнийг Шивээхүрэн, Гашуунсухайт хилийн боомт, мөн “Уурхайн ам” нөхцлөөр зарлаж байх.
 - Төмрийн баяжмалын үнийг “Эрээн”, “Бургастай” хилийн боомтоор зарлаж байх.
 - Жоншийг Эрээн ба Наушкаар зарлаж байх.



Үнэ тогтоох аргачлалыг боловсронгуй болгох арга зам

4. АНУ, Канад, Индонез, Австрали болон Казакстан зэрэг уул уурхай эрчимтэй хөгжиж буй орнуудад жишиг үнэ тооцоолдог арга туршлагыг манай оронд мөрдөж буй аргачлалттай харьцуулан судлах, ингэхдээ экспортын контрактын бодит үнэ олон улсын зах зээлийн үнээс дээгүүр эсвэл доогуур байх нөхцөлд жишиг үнэд тохируулга хийдэг механизм, мөн борлуулалтын үнийн дүнгээс боловсруулалтын зардал зэргийг хасдаг олон улсын механизмыг судалж манай орны нөхцөлд ашиглах;



Анхаарал тавьсанд баярлалаа

Утас: 99119356

info@exportmongolia.mn

